Батлан хамгаалах яам, Зам тээврийн яам, Батлан хамгаалах их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хvрээлэнгээс хамтран “Зvvн Хойд Азийн дэд бvтцийн стратегийн ач холбогдол, хогжлийн чиг хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2016 оны 5-р сарын 27-ны одор Гадаад хэргийн яамны “Зовшилцол” танхимд амжилттай зохион байгууллаа.



Хуралд Батлан хамгаалах яамны торийн нарийн бичгийн дарга Б. Батсайхан, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого толовлолтийн газрын дарга, Бригадын генерал Г. Сайханбаяр, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга Бригадын генерал Ч. Сосорбарам, Зэвсэгт хvчний жанжин штабын Бодлого, Стратегийн толовололтийн газрын дарга Бригадын генерал Ж. Бадамбазар, БХИС-ын сургалт эрхэлсэн дэд

захирал, хурандаа Д. Баасандамба, БХИС-ын Эрдэм шинжилгээ, нийгмийн тvншлэлийн асуудал эрхэлсэн дэд захирал П. Жаргалан, Зам тээврийн яамны Техник, технологи, нормативийн хэлтсийн дарга М. Угтахбаяр, Зам тээврийн яамны Стратегийн бодлого толовлолт, хамтын ажиллагааны газрын даргын vvрэг гvйцэтгэгч Ю. Олзийжаргал нараас гадна БНХАУ-ын Олон Улсын Стратегийн судалгааны Хvрээлэнгийн ахлах судлаач, ахлах хурандаа Чень Вэй, Чень Фанмин, ОХУ-ын Улаан Үд хотын Ходоо аж ахуйн аладемийн доктор, профессор Вячеслав Дамбаев, ЖАЙКА-гийн Монгол дахь толоологчийн газрын дарга Сато Мvцvми, Зам тээврийн яамны зовлох Кан Жейхун нарын гадны зочид толоологчид болон Монгол Улсад суух зарим элчин сайдын яамдын цэргийн атташе нар оролцлоо.

Мон БХЭШХ болон Монгол Улсад vйл ажиллагаа явуулдаг бусад судалгааны байгууллагуудын эрдэмтэн судлаачид тэргvvтэй 100 гаруй зочид, толоологчид, оролцож, бvс нутгийн дэд бvтцийн аюулгvй байдлын тулгамдсан асуудлуудаар санал бодлоо солилцоод зогсохгvй БХЭШХ, ШУА-ын Олон Улсын харилцааны хvрээлэн, Стратегийн судалгааны хvрээлэн, Геополитикийн хvрээлэн, Энх тайван, аюулгvй байдлын судалгааны “Цэнхэр свлд” нийгэмлэг, ШУТИС, Зvvн Хойд Азийн дэд бvтцийн судалгааны хvрээлэнгийн эрдэмтэн судлаачид холбогдох асуудлаар сонирхолтой илтгэл тавьж хэлэлцvvлсэн богоод тэр дундаа эрдэм шинжилгээний хурлын vндсэн илтгэлvvдийг БХЭШХ-ийн захирал, хурандаа Б. Монхсайхан,ЗТЯ-ны Стратегийн бодлого толовлолт, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн С. Батболд нар тавьжээ.

Батлан хамгаалах яам, Батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хvрээлэнгийн зvгээс жил тутам бvс нутгийн аюулгvй байдлын асуудлаар олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж байгаа богоод 2013 онд “Зvvн хойд Азийн аюулгvй байдал”, 2014 онд “Зvvн хойд Азийн эрчим хvчний аюулгvй байдал”, 2015 онд “Зvvн хойд Азийн хvрээлэн буй орчны аюулгvй байдал” гэсэн сэдвvvдээр амжилттай зохион байгуулж байсан.